



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Уурхайчин баг, ЦТП-3/3 салаа ДУ159 мм-ийн шугамыг шинэчлэн солих ажил”-ын хүрээнд бий болсон нийт 197,169,000.00 (нэг зуун ерэн долоон сая нэг зуун жаран есөн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Бат-Эрдэнэ, Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Оюунгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД